

Академич, профессор Д. БАТСУУРЬ

Монгол улсын их сургуулийн ахмад багш, хатуу биеийн физикийн салбарын ууган эрдэмтэн, ШУА-ийн гишүүн, МУИС-ийн дэд захирлаар он удаан жил ажиллаж байсан профессор Дамбаравжаагийн Батсуурь 1925 онд Завхан аймгийн Сонгино суманд төржээ.

Академич, профессор Д.Батсуурь МУИС-ийн физик-математикийн салбарыг 1947 онд төгсч 1947-1990 онд МУИС-д физикийн багш, тэнхмийн эрхлэгч, эрдэм шинжилгээ, гадаад харилцаа эрхэлсэн дэд захирлаар тасралтгүй ажиллаж бүхий л амьдралаа МУИС-тэй, монгол улсын боловсрол, шинжлэх ухаанд зориулсан манай улсын ууган сэхээтнүүдийн нэг байсан юм.

Эрдэмтэн багш Д.Батсуурь 1953 онд Москвагийн их сургуулийн аспирантурт суралцан *"Налархай деформацид орсон металлын оронт торын эвдрэлийг рентгенографын аргаар судалсан нь"* хэмээх сэдвээр физик-математикийн ухааны дэд эрдэмтний зэрэг хамгаалснаар манай улсын гурав дахь физикч эрдэмтэн болсон юм. Энэхүү эрдмийн ажилдаа кристалл дахь механик эвдрэл, хүчдлийн зүй тогтлыг рентген туяаны сарнилын аргаар судлах аргачлал, торын эвдрэлийн шинж чанар нь уг кристаллын хайлах температуртай хамааралтай болохыг никель, зэс, вольфрам зэрэг металлын хувьд тогтоож, үр дүнгээ хамгаалсан байна.

Профессор Д.Батсуурь 1957-1959 онд ЗХУ-аас УРС-70, УРС-55, УРС-50М төрлийн тоног төхөөрөмжүүдийг захиалан авчирч МУИС-д Рентген бүтцийн судалгааны анхны лабораторийг байгуулсан нь сургалт-эрдэм шинжилгээг хослон явуулах эхлэлийг тавьсан байна.

Анх 1958 онд профессор Д.Батсуурь ШУА-ийн Байгалийн ухааны хүрээлэнд "Рентген ба спектр судлалын тасаг" нэртэй эрдэм шинжилгээний лаборатори байгуулснаар хатуу биеийн физикийн эрдэм шинжилгээний ажлын эхлэл манай улсад тавигджээ.

Профессор Д.Батсуурийн монгол улсад шинжлэх ухаан, ялангуяа хатуу биеийн физикийн чиглэлийг үүсгэж хөгжүүлсэн зүтгэлийг төр, засгаас үнэлэн 1961 онд Сайд нарын Зөвлөлийн тогтоолоор ШУА-ийн сурвалжлагч гишүүнээр баталж 7 тоот гэрчилгээ олгосон ба 1990 онд ШУА-ийн гишүүнээр сонгосон явдал юм.

Академич Д. Батсуурь 1966 оноос орчин үеийн электроникийн үндсэн "түүхий эд" болох хагас дамжуулагч материалын судалгааны чиглэлийг эхлүүлсэн юм. Энэ сэдвийн хүрээнд өөрийн орны ашигт малтмал, эрдэс бодист агуулагдах хагас дамжуулагч химийн элементийн судалгаа, зарим материалыг лабораторийн нөхцөлд ургуулах ба цэвэрлэх төхөөрөмжийг зохион бүтээх, турших, гарган авсан монокристаллын физик шинж чанар, кристалл бүтцийг судлах зэрэг ажлуудыг гүйцэтгэсэн болно.

Судалгааны дараагийн шат нь нарны энергийг цахилгаан энерги болгон шууд хувиргахад өргөнөөр хэрэглэгддэг кадми теллур зэрэг хаалттай бүсийн өргөн нь их байдаг хагас дамжуулагч материалын судалгаа байсан юм. Үүний зэрэгцээ цахиур суурь бүхий фотодиод, нарны элемент хийх технологийг боловсруулж, практикт нэвтрүүлсэн байна.

1986 оноос электроникийн тухайн үеийн нэн шинэ материал гэж тооцогдох аморф цахиурын судалгааг эхлүүлэн гадаад хамтын ажиллагааг энэ чиглэлд тогтоосон нь одоо хүртэл үргэлжилж байна.

Монгол-Зөвлөлтийн хамтарсан сансрын нислэгийн үеэр хагас дамжуулагчийн технологийн Алтай-1, Алтай-2 программыг удирдан гүйцэтгэсэн билээ.

Судалгааны үр дүнг үйлдвэрлэл, практикт нэвтрүүлэх талаар Төмрийн заводын ширэмний микро бүтэц, шаазан эдлэлийн үйлдвэрлэлийн дулааны горим, шаврын орд газрын эрдсийн судалгаа, гал гарсан шалтгааныг тодорхойлох рентгенографийн арга, хүний гүдний цайсан болорлогийг авах мэс засалын багаж зэрэг түүний удирдлагаар хийгдсэн олон ажлыг дурьдаж болно.

Академич Д. Батсуурийн 30-иад жилийн нөр их хөдөлмөр, зүтгэлийн дүнд хатуу бие, хагас дамжуулагчийн физикийн олон төрөлт судалгааны чиглэл бүхий эрдэм шинжилгээний шавь сургууль бүрэлдэн тогтсон юм.

Профессор Д.Батсуурь бол шинжлэх ухаан, боловсролын чадамгай зохион байгуулагч байсан юм. Түүний санаачилгаар анх МУИС, ШУА-ийн дэргэд хатуу биеийн физикийн судалгаа явуулдаг хамтын лаборатори байгуулсан нь өөрийн орны мэргэжилтний хүчийг төвлөрүүлэх, ховор багаж,

Академич, профессор

Д.БАТСУУРЬ-80 жил



Академич, Профессор Д.Батсуурь (1925-1991).